

<https://doi.org/10.65816/jsds.2025.04.007>

Их гүрнүүдийн тусгай албадын батлан хамгаалах салбарт чиглэсэн стратегийн өөрчлөлт ба шинэ чиг хандлага

Н.Гэрэлт-Од

Аюулгүй байдал судлалын хүрээлэн

ABSTRACT

As the international strategic environment changes rapidly, major powers are beginning to implement new strategies and methods in their special services and intelligence operations in the defense sector. This article compares China's "Three War Missions", the US ODNI 2.0 reform, and some aspects of the "quality-to-quantity" approach of Russian special services.

China's "Three War Missions" is a strategy to neutralize an opponent without fighting using information, psychological, and legal means. The US ODNI 2.0 is a restructuring of the country's intelligence agencies, focusing on operational coherence and efficiency, and is aimed at ensuring national security. This article emphasizes that since the war in Ukraine, Russia has shifted from a small number of trained forces to a large number of untrained individuals in its intelligence and influence operations, and has begun to use tactics to pressure opponents with large numbers of people. These changes demonstrate the increasing role of special services and the importance of information-psychological tools in the strategic competition of great powers, and it is important for other countries to study and understand this and incorporate it into their policy planning.

Keywords: *special service; strategic innovation; Three War Doctrine; ODNI 2.0; from Quality to uantity.*

ОРШИЛ

Олон улсын харилцаанд “тектоник” шинжтэй өөрчлөлт өрнөж, дэлхийн хүчний харьцаа шилжих энэ цаг үед их гүрнүүдийн зөрчил, сөргөлдөөн эрчимжиж байна. Үүний улмаас улс орнууд батлан хамгаалах салбарын төсвөө нэмэгдүүлэх, зэвсэг техникээ шинэчлэх, стратеги бодлогоо дахин шинэчлэн боловсруулах зэрэг алхмуудыг хийж батлан хамгаалах салбартаа ихээхэн анхаарал хандуулах боллоо. Батлан хамгаалах стратегийн үндсэн бүрэлдэхүүн хэсгийн нэг болох зэвсэгт хүчний эрхэм зорилго нь улсынхаа аюулгүй байдлыг хангах, байлдааны бэлэн байдлаа хадгалах, гадаадын түрэмгийлэгчдийг няцаах, эх орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалж улмаар зэвсэгт мөргөлдөөнд ялалт байгуулахад оршдог. Энэ эрхэм зорилгод дэмжлэг үзүүлэх нэг чухал хүчин зүйл нь тусгай албадын үйл ажиллагаа юм.

Энэхүү өгүүлэлд дэлхийн бодлогод голлох нөлөөтэй гурван улс БНХАУ, АНУ, ОХУ-ын тусгай албадын батлан хамгаалах бодлогод гүйцэтгэх үүргийн

хүрээнд сүүлийн үеийн зарим стратегийн өөрчлөлт, шинэчлэлийн чиг хандлагыг авч үзэхийг оролдов. Ийнхүү харьцуулан судалснаар өнөөгийн нөхцөл байдалд манай улс тулгарч болзошгүй аюул занал, сорилтыг урьдчилан танин мэдэж, түүнд тохирсон хариу арга хэмжээг төлөвлөн боловсруулахад хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

БНХАУ: Дайны 3 номлол

Хятадын ардын чөлөөлөх армийн (ХАЧА) орчин цагийн цэргийн номлол, стратеги, тактикт 1991 онд Персийн буланд АНУ-аас явуулсан “Цөлийн шуурга” цэргийн ажиллагаа¹ болон 2003 оны Иракийн дайн хүчтэй нөлөө үзүүлжээ. ХАЧА-ийн Цэргийн шинжлэх ухааны академи, Стратегийн академийн захирал асан, хошууч генерал Ван Пуфөн “Цөлийн шуурга” ажиллагааг дүгнэхдээ “Дайн зөвхөн буу зэвсэг хэрэглэсэн байлдааны талбарт бус харин компьютержсэн орчин лаборатори, командын байрнаас ч явагдах болжээ... Тэнд маш олон шинэ асуудал байгаа бөгөөд бид олж судлах ёстой”² гэж онцолсон юм. Мөн 2003 оны Иракийн дайны үйл явцын талаар Хятадын цэргийн шинжээчдийн судалгаатай танилцсаны дараа ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Зян Зөминь цэргийн стратеги, тактикт “Дайны 3 номлол” буюу онолын дайн, эрх зүйн дайн болон сэтгэлзүйн дайны байр суурийг чухалчлан хөгжүүлэх зайлшгүй шаардлагатайг онцолсон байна. Үүний дагуу “Хятадын ардын чөлөөлөх армийн улс төрийн ажлын дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Хятадын батлан хамгаалах стратегийн эргэлтийн цэг болсон хэмээн судлаачид тэмдэглэдэг³.

Өдгөө ХАЧА-ийн улс төр, үзэл суртлын гол номлол болсон “Дайны 3 номлол”-ыг Хятадын Цэргийн төв зөвлөлийн Стратегийн дэмжлэг үзүүлэх хүчин, Улс төрийн хэлтэс, Улс төр, хуулийн хэлтэс тус тус хариуцан харилцан нягт уялдаа холбоотойгоор цогцоор нь хэрэгжүүлж байна⁴.



Зураг 1. “Дайны 3 номлол”-ыг хариуцан хэрэгжүүлэх бүтэц

¹ Commander Michael Dahm, U.S. Navy (Retired), “China’s Desert Storm Education”, March 2021. China’s Desert Storm Education | Proceedings - March 2021 Vol. 147/3/1,417 (usni.org)

² Ван Пуфөн, “Мэдээллийн дайны сорилтууд”, Хятадын цэргийн шинжлэх ухаан, №1, 1995. THE CHALLENGE OF INFORMATION WARFARE Major General Wang Pufeng (fas.org)

³ 劉文傑, [淺談中共當前對台三戰作為], 裝甲兵季刊, 第259期/民國110年3月, 頁21. https://www.mnd.gov.tw/NewUpload/202103/2-%E4%B8%AD%E5%85%B1%E7%95%B6%E5%89%8D%E5%B0%8D%E5%8F%B0%E4%B8%89%E6%88%B0%E4%BD%9C%E7%82%BA-%E5%8A%89%E6%96%87%E5%82%91_413844.pdf

⁴ 陳津萍, [習近平軍改前後「三戰」組織架構轉變研析], 陸軍學術雙月刊, 第五十四卷第559期/2018年6月, 頁 54. https://www.mnd.gov.tw/NewUpload/201805/p39-58_305151.pdf

Энэ номлолын гол зорилго нь зэвсэгт хүчнээ сөргөлдөгчийн нутаг дэвсгэрт оруулахын өмнө өөрт ашигтай стратегийн орчныг бүрдүүлэх, эсвэл цэргийн хүч шууд хэрэглэхгүйгээр өрсөлдөгчийг буулган авахад оршино. Өөрөөр хэлбэл “Дайны 3 номлол” нь эсрэг талын зэвсэгт хүчин, армийг хэрэгцээгүй, чадваргүй болгон мэдээлэл, сэтгэл зүйн аргаар саармагжуулж, байлдааны ажиллагаанд оролцох шаардлагагүйгээр ялахыг зорьсон номлол гэж үзэж болно.

Хятадын Цэргийн шинжлэх ухааны академийн Улс төр судлалын хүрээлэнгийн дэд захирал Гун Фанбин уг номлолын мөн чанарыг тодорхойлохдоо “Энэ нь бүх төрлийн эх үүсвэрийг нэгтгэн, улс төр, үзэл суртал, оюун санаа, сэтгэл зүй, эрх зүйн талбарт эсрэг талд довтолгоо хийж зорилгодоо хүрэх байлдааны бус хэлбэр юм. Энэхүү үйл ажиллагаа нь цэргийн хүч хэрэглэхийн өмнө, хэрэглэх явцад болон хойно нь ч үргэлжлэх шинжтэй. Өөрөөр хэлбэл бага хүчээр их ялалтад хүрэх буюу байлдахгүйгээр эсрэг талаа буулган авах үйл ажиллагаа юм”⁵ гэжээ.

АНУ: ODNI 2.0 шинэчлэл

2025 оны 8 сарын 20-нд АНУ-ын Үндэсний тагнуулын захирал (Director of National Intelligence) Тулси Габбард тагнуулын байгууллагуудын үйл ажиллагааг шинэ шатанд гаргах “ODNI 2.0” санаачилгаа танилцуулж, өөрчлөлт шинэчлэлийн эхлэлийг зарлав. Энэхүү шинэчлэлийн гол зорилго нь Америкийн үндэсний ашиг сонирхлыг хангах, ард иргэдийнхээ аюулгүй байдал, эрх чөлөөг хамгаалахад чиглэж байна гэж тэрээр онцолсон юм.⁶ Габбардын хэрэгжүүлсэн томоохон өөрчлөлтийн нэг нь Гадаадын хортой нөлөөлөлтэй тэмцэх төв-ийг татан буулгаж үйл ажиллагааны интеграцийн газар болон Үндэсний тагнуулын зөвлөлд шилжүүлэн нэгтгэсэн явдал байв. Үүнийг АНУ гадаад улсуудын хорт нөлөөллийн эсрэг тэмцэхээс ухарч буй хэрэг огт биш, харин ч тусгай албаны бүхий л нэгж, алба бүр өөр өөрийн үйл ажиллагааныхаа хүрээнд гадаадын нөлөөллийн эсрэг илүү өргөн цар хүрээтэй, мэргэшсэн түвшинд тэмцэх шинэ зохион байгуулалт гэж үзэж болно.⁷ Түүнчлэн тус албыг улс төрчид өөрсдийн зорилгод ашиглах байдлыг таслан зогсоох үүднээс Габбард ODNI (Үндэсний тагнуулын захиргааны төв аппарат)-н нийт ажиллах хүчнийг 40 хувиар цомхотгохоор шийдвэрлэжээ.⁸ Ажиглагчдын дүгнэснээр энэ нь тусгай албадын ажиллагааг улс төрийн нөлөөллөөс ангид байлгах, үндсэн зорилгоос нь гажуудуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн том алхам болсон байна. Ингэснээр АНУ-ын тагнуулын агентлагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо илүү сайжирч, үндсэн зорилтууддаа төвлөрсөн

⁵ 公方彬,「輿論戰心理戰法律戰正式成爲中國軍隊的作戰樣式一」, 中國青年報(2004年4月11日). <http://news.beelink.com.cn/20040411/1560388.shtml>

⁶ ODNI 2.0: With Trump's 'Greenlight' Gabbard Launches Historic Intel Overhaul. RealClearPolitics 2025. https://www.realclearpolitics.com/articles/2025/08/20/odni_20_with_trumps_greenlight_gabbard_launches_historic_intelligence_overhaul_153198.html

⁷ Exclusive: Senate Republicans Say Gabbard 'Knocked It Out of the Park' with ODNI Transformation. Breitbart 2025. <https://www.breitbart.com/politics/2025/08/21/exclusive-senate-republicans-say-gabbard-knocked-it-out-park-odni-transformation/>

⁸ ODNI 2.0: With Trump's 'Greenlight' Gabbard Launches Historic Intel Overhaul. RealClearPolitics 2025. https://www.realclearpolitics.com/articles/2025/08/20/odni_20_with_trumps_greenlight_gabbard_launches_historic_intelligence_overhaul_153198.html

өндөр ур чадвартай мэргэшсэн хүний нөөц бүхий шинэ бүтцээр ажиллах боломж бүрдсэн ажээ.

ОХУ: Чанараас тоо руу стратеги

Барууны шинжээчдийн үзэж буйгаар 2022 онд Украинд дайн эхэлснээс хойш ОХУ-ын тусгай албадын үйл ажиллагааны стратеги эрс өөрчлөгдөж эхэлсэн байна. ЗХУ-ын үед тагнуул, мэдээллийн ажиллагаа нь намын хяналт дор, үзэл сурталд суурилан, нарийн судалгаа төлөвлөлттэй, өндөр мэргэшсэн бүтэц зохион байгуулалттай явагддаг байсан бол сүүлийн үед Оросын тусгай албад урьдчилан сайтар бэлтгэгдээгүй олон тооны иргэдийг нийгмийн цахим сүлжээгээр элсүүлэн, нэг удаагийн журмаар ашиглах замаар өргөн хүрээнд хорлон сүйтгэх болон нөлөөллийн ажиллагаа явуулж буй нь ажиглагдаж байна.

Украины фронтод Оросын зэвсэгт хүчин хүний тооны давуу талаа ашиглан асар их хохирол гарган давших “махны машин” тактик хэрэглэж байгаа нь тус улсын тусгай албаны арсеналд ч тусгалаа олж байна гэж АНУ-ын Тэнгисийн цэргийн дүн шинжилгээний төвийн нэгэн судалгаанд дурдсан байна.⁹ Тодруулбал, 2014 онд ОХУ Крымийг эзлэн түрэмгийлснээс үүдэн барууны хориг, шахалттай тулгарч өрнөдийн орнууд оросын иргэдэд виз олгохыг хязгаарлан, Европ дахь Оросын нууц тагнуулуудыг илрүүлэн нутгаасаа гаргаснаар уламжлалт тагнуулын арга барилаа хэрэгжүүлэх боломж нь хумигджээ¹⁰. Ийм нөхцөл байдалд оросын тал цахим сүлжээний мессенжерүүдээр дамжуулан богино хугацаанд ашиглах боломжтой олон тооны “түр ажилтан” элсүүлэх стратегийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Санхүүгийн нэн яаралтай хэрэгцээтэй хүмүүс, дүрвэгсэд, залуу гэмт хэрэгтнүүд, өрнөдөд оршин суух орост элэгтэй хүмүүс болон хялбар ашиг хайгчид зэрэг нь энэ сүлжээнд өртөж тусгай албад тэднийг хөлслөн ашиглах болжээ.¹¹ Ингэхдээ даалгавар бүрийг бичил “атомчилсан” хэсгүүдэд хуваан хүн тус бүрд оноож¹² гүйцэтгүүлдэг тул оролцогчид нийт ажиллагааны төлөвлөгөөг бүрэн мэдэхгүй, улмаар мэдээлэл алдах эрсдэл багасаж, ажиллагааны зардал хямдардаг байна. Ийм өргөн сүлжээ бүхий, чанарын хяналт сул олон тооны ажиллагааг давхар хэрэгжүүлж, түүндээ бэлтгэгдээгүй этгээдүүдийг татан оролцуулснаар амжилтгүй ажиллагаа нь хүртэл нийгмийг айдас түгшүүрт автуулах, иргэд олон

⁹ *Quantity Has a Quality All of Its Own*. CNA 2025. <https://www.cna.org/analyses/2025/05/quantity-has-a-quality-all-of-its-own>

¹⁰ “European Union: Council Suspends Visa Facilitation Agreement with Russia,” *Library of Congress*, Sept. 20, 2022, <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2022-09-20/european-union-council-suspends-visa-facilitation-agreement-with-russia/>; Anastasia Dagaeva, “Turbulent Times: How Russian Airlines Are Weathering the Storm,” *Carnegie Politika*, Mar. 28, 2023, <https://carnegieendowment.org/russia-eurasia/politika/2023/02/turbulent-times-how-russian-airlines-are-weathering-the-storm?lang=en>; Sergei Kanev, “Отлетались. Как из-за войны с Украиной развалилась резиденция ГПУ в «Аэрофлоте» и где теперь эти шпионы,” *The Insider*, June 9, 2023, <https://theins.info/obshchestvo/262031>.

¹¹ Paul Adams, “Russia’s ‘Meat-Grinder’ Tactics Bring Battlefield Success - but at Horrendous Cost,” *BBC*, Dec. 6, 2024, <https://www.bbc.com/news/articles/c0ewneynypwo>; Becky Alexis-Martin, “Russia’s ‘Meat Grinder’ Tactics in Ukraine Have Proved Effective in Past Wars – but at Terrible Cost,” *The Conversation*, Oct. 21, 2024, <http://theconversation.com/russias-meat-grinder-tactics-in-ukraine-have-proved-effective-in-past-wars-but-at-terrible-cost-241688>.

¹² Richterova et al., “Russian Sabotage in the Gig-Economy Era,” p. 16

нийтийн итгэлийг сулруулах, зэвсэгт хүчин, хууль сахиулах болон тагнуулын байгууллагын нөөц бололцоог тарамдуулах, шавхан сульдүүлэх эрсдэлтэй болов. Товчхондоо Оросын тусгай албадын стратеги нь “чанараас тоо руу” буюу олон тооны ажиллагааг олон хүний хүчээр чанарын нарийн хяналтгүйгээр, хурдан шуурхай, өргөн цар хүрээнд гүйцэтгэх хандлагад шилжсэн гэж дүгнэж болох юм. АНУ-ын Тэнгисийн цэргийн дүн шинжилгээний төвийн нэгэн судалгаанд Оросын тагнуулын стратегийн өөрчлөлтийг “хүний олноор өрсөлдөгчөө дарамтлах” шинэ тактик хэмээн нэрлэжээ¹³.

ДҮГНЭЛТ

Дэлхийн стратегийн өрсөлдөөний хурцадмал нөхцөлд их гүрнүүд батлан хамгаалах бодлогодоо тусгай албадын оролцоог эрс идэвхжүүлж, шинэ арга барил, чиг хандлагыг төлөвшүүлж байна. БНХАУ-ын “Дайны 3 номлол” нь зэвсэг хэрэглэхгүйгээр мэдээлэл, сэтгэл зүй, хууль эрх зүйн давуу талыг бүрдүүлэн өрсөлдөгчөө сулруулах стратеги гэж тодорхойлогддог. АНУ-ын ODNI 2.0 шинэчлэл нь тагнуулын байгууллагын дотоод бүтцэд өөрчлөлт оруулж, нөөц бололцоог оновчтой хуваарилан, үндсэн зорилгодоо илүү төвлөрсөн үр ашиг өндөртэй систем бүрдүүлэх зорилготой. Харин ОХУ-ын хувьд Украин дахь дайны нөхцөл байдалд зохицуулан, мэдээлэл-технологийн дэвшил, нийгмийн сүлжээг ашиглан олон тооны хүнийг татан оролцуулсан өргөн хүрээний нөлөөллийн ажиллагаагаар дайсандаа дарамт үзүүлэх шинэ тактик хэрэгжүүлж эхэлжээ.

Эдгээр жишээнүүд нь өнөөгийн их гүрнүүдийн өрсөлдөөнд уламжлалт цэрэг-байлдааны аргаас гадна мэдээлэл, сэтгэл зүй, хууль эрх зүйн талбар дахь “далд” тэмцэл, зохион байгуулалтын шинэчлэл улам хүч түрэн орж ирж буйг харуулж байна. Тиймээс бид энэ төрлийн өөрчлөлт шинэ хандлагуудыг анхааралтай судалж, өөрийн аюулгүй байдлын орчинд үнэлгээ хийх, шаардлагатай бодлого, төлөвлөгөөг боловсруулах нь зайлшгүй болоод байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Commander Michael Dahm, U.S. Navy (Retired), “China’s Desert Storm Education”, March 2021. China’s Desert Storm Education | Proceedings - March 2021 Vol. 147/3/1,417 (usni.org)
2. Ван Пуфөн, “Мэдээллийн дайны сорилтууд”, Хятадын цэргийн шинжлэх ухаан, №1, 1995. THE CHALLENGE OF INFORMATION WARFARE Major General Wang Pufeng (fas.org)
3. 劉文傑, [淺談中共當前對台三戰作為], 裝甲兵季刊, 第259期/民國110年3月, 頁 21.
4. 陳津萍, [習近平軍改前後 「三戰」組織架構轉變研析], 陸軍學術雙月刊, 第五十四卷第559期/2018年6月, 頁 54. https://www.mnd.gov.tw/NewUpload/201805/p39-58_305151.pdf
5. 公方彬, 「輿論戰心理戰法律戰正式成為中國軍隊的作戰樣式—」, 中國青年報 2004年4月11日) . <http://news.beelink.com.cn/20040411/1560388.shtml>

¹³ Quantity Has a Quality All of Its Own. CNA 2025. <https://www.cna.org/analyses/2025/05/quantity-has-a-quality-all-of-its-own>

6. ODNI 2.0: With Trump's 'Greenlight' Gabbard Launches Historic Intel Overhaul. RealClearPolitics 2025. https://www.realclearpolitics.com/articles/2025/08/20/odni_20_with_trumps_greenlight_gabbard_launches_historic_intelligence_overhaul__153198.html
7. Exclusive: Senate Republicans Say Gabbard 'Knocked It Out of the Park' with ODNI Transformation. Breitbart 2025. <https://www.breitbart.com/politics/2025/08/21/exclusive-senate-republicans-say-gabbard-knocked-it-out-park-odni-transformation/>
8. ODNI 2.0: With Trump's 'Greenlight' Gabbard Launches Historic Intel Overhaul. RealClearPolitics 2025. https://www.realclearpolitics.com/articles/2025/08/20/odni_20_with_trumps_greenlight_gabbard_launches_historic_intelligence_overhaul__153198.html
9. Quantity Has a Quality All of Its Own. CNA 2025. <https://www.cna.org/analyses/2025/05/quantity-has-a-quality-all-of-its-own>
10. "European Union: Council Suspends Visa Facilitation Agreement with Russia," Library of Congress, Sept. 20, 2022, <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2022-09-20/european-union-council-suspends-visa-facilitation-agreement-with-russia/>; Anastasia Dagaeva, "Turbulent Times: How Russian Airlines Are Weathering the Storm," Carnegie Politika, Mar. 28, 2023, <https://carnegieendowment.org/russia-eurasia/politika/2023/02/turbulent-times-how-russian-airlines-are-weathering-the-storm?lang=en>; Sergei Kanev, "Отлетались. Как из-за войны с Украиной развалилась резидентура ГРУ в «Аэрофлоте» и где теперь эти шпионы," The Insider, June 9, 2023, <https://theins.info/obshestvo/262031>.
11. Paul Adams, "Russia's 'Meat-Grinder' Tactics Bring Battlefield Success - but at Horrendous Cost," BBC, Dec. 6, 2024, <https://www.bbc.com/news/articles/c0ewneynypwo>; Becky Alexis-Martin, "Russia's 'Meat Grinder' Tactics in Ukraine Have Proved Effective in Past Wars – but at Terrible Cost," The Conversation, Oct. 21, 2024, <http://theconversation.com/russias-meat-grinder-tactics-in-ukrainehave-proved-effective-in-past-wars-but-at-terrible-cost-241688>.
12. Richterova et al., "Russian Sabotage in the Gig-Economy Era," p. 16
13. Quantity Has a Quality All of Its Own. CNA 2025. <https://www.cna.org/analyses/2025/05/quantity-has-a-quality-all-of-its-own>